

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2020

ЦЕМЕНТИЙН ҮНЭ БУУРАХ УУ?

С.Уранчимэг¹

<i>JEL ангилал:</i> E22, D2, L11 <i>Түлхүүр үг:</i> Барилгын салбар, цементийн үнэ, импорт, экспорт	<i>Хураангуй:</i> Энэхүү нийтлэлд барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг төр, засгаас 2013 оноос хэрэгжүүлснээр цементийн нийт хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээр хангадаг болж, валютын гадагшлах урсгалыг зогсоосон боловч өндөр өртөг бүхий үйлдвэр, өсөн нэмэгдсэн ханштай уялдсан худалдан авалтын нэмүү өртөг, дээр нь нэгж бүтээгдэхүүний өртөгт сууж буй санхүүгийн зардлын өсөлт голлох байр суурьтай байгаа учраас цементийн үнэ буурах болов уу гэсэн асуудлыг судлаач дэвшүүлжээ.
--	--

Монгол улсад барилгын салбар үүсч хөгжөөд даруй 94 жилийг ардаа орхижээ. Анхны цементийн үйлдвэр бий болоод 52 жил болж, улсад нийт том жижиг нийлсэн гарын арван хуруунд багтах хэмжээний үйлдвэр бие даан үйл ажиллагаа явуулж, жилийн нийт үйлдвэрлэлийн төслийн хүчин чадал нь 4,5-5 сая тоннд хүрчээ.

Өнгөрсөн хугацаанд манай орны цементийн жилийн нийт хэрэглээ нь дээд тал нь 1,8–1,9 орчим сая тоннд хэлбэлзэж ирсэн байдаг. Дотоодын томоохон үйлдвэрлэгчид ашиглалтад орохоос өмнөх он жилүүдэд импортын буюу хятадын цемент монголын зах зээлийг эзэлж, монополь үйл ажиллагаа явуулдаг, үнийн бодлого хэрэгжүүлдэг, энэ хэрэгцээгээр валютын гадагшлах урсгал их байсан ажээ.

Цементийн үндсэн түүхий эд нь шохойн чулуу. Устай урвалд орж, бэхжин хүний гараар бүтээгддэг чулуу болон хувирдаг “цемент” хэмээх гайхамшигт нунтаг бүтээгдэхүүнийг шохойн чулуу ба шаварлаг түүхий эдийн хуурай хольцоос тус тус бэлтгэн, цементийн урьдчилан шатаагч зууханд 600°C (1,112°F)-ээс шохойн чулууны задралын хэм хүртэл халаан задалж, улмаар 1450°C буюу 2,640°F орчим хэм хүртэл шатаан хайлуулах замаар орчин үеийн “цементийн чулуунцар” буюу “клинкер” хэмээх материалыг гарган авдаг аж. Энэхүү чулуунцарт алит (alite), белит (belite), алюминат, буюу алюмоферрит гэсэн клинкерийн дөрвөн үндсэн фаз буюу эрдэс агуулагдах бөгөөд 3-5 хувийн гөлтгөнийг нэмж, хамт нунтагласнаар “цемент” хэмээх устай зуурангуут урвалд орж, бидний хүссэн орц, хэмжээ, дүрс хэлбэрт чулуужин хатуурч, бат бэхээ хэдэн

¹ “Цемент шохой” ХК-ийн Санхүү, эдийн засаг хариуцсан захирал.


Цахим шуудан: suranch.bgn@gmail.com

арван жилээс, хэдэн зуун жил хадгалж оршиж чадахуйц “цемент бетоны талст” хэмээх материалыг бүтээдэг ажээ. Цементийг дээр өгүүлсэн шиг өндөр хэмтэй халуунд боловсруулахад шаардлагатай үндсэн түүхий эд нь өндөр калорилаг чанар бүхий нүүрс. Ингээд байгалийн энгийн шохойн чулууг бүтээгдэхүүн болгох үйл явцыг бүтээгч тусгай технологи бүхий тоног төхөөрөмж, байгууламж, дээр нь хүний оюун ухаан, ажиллагсдын уйгагүй хүч хөдөлмөр юм.

Монгол Улсын Засгийн газраас 2013-2015 онд хэрэгжүүлсэн нэг томоохон арга хэмжээ нь “Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”² байсан юм. Энэ хөтөлбөрийн хүрээнд бага хүүтэй зээлийг барилгын материал импортлогч, дотоодын үйлдвэрлэгчид олгосон байдаг. Уг зохицуулалтын хүрээнд зах зээлд нийлүүлэгдэж буй цементийн үнэ үйлдвэрлэгч компаниудад хэсэг хугацаанд тогтворжиж үнийн савлагаа ажиллагдаагүй билээ.

Зураг 1

Дотоодын болон импортын цементийн нийлүүлэлтийн харьцаа, %



Эх сурвалж: ҮСХ-ны статистик мэдээлэл, зохиогчийн тооцоогоор

Зураг 1-ээс харахад, цементийн дотоодын нийт хэрэглээнд импортын цементийн эзлэх хувь хэмжээ 2013 онд оргил үедээ буюу 85 хувьд хүрч байсан бол 2014-2017 онд огцом буюу 7 дахин буурч, харин цементийн дотоодын үйлдвэрлэлийн эзлэх хувь хэмжээ 2013 онд 15 хувь байсан бол өндөр хурдацтай өсч, өнөө үед дотоодын хэрэглээг бүрэн хангаж байна.


2014 онд Хөтөлийн “Цемент Шохой” ХК нь үйлдвэрлэлтийн өртөг өндөр, хуучин нойтон аргаар цемент боловсруулах технологийг халж, шинэ хуурай аргаар боловсруулах жилд нэг сая тонн цемент үйлдвэрлэх шугамыг ашиглалтад

² Засгийн газрын 2012 оны 171 дүгээр тогтоолоор баглагдсан. <https://www.legalinfo.mn/annex/details/5709?lawid=8892>

оруулж, түүний дараагаар 2015 онд “Монцемент Бьюлдингс Материалс” ХХК-ийн нэг сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр, “Мөнхийн Баян Гал” ХХК-ийн БНХАУ-ын хөрөнгө оруулалттай нэг сая тонны цементийн үйлдвэр, 2016 онд “Монголын Алт” ХХК-ийн мөн нэг сая тонны үйлдвэр ашиглалтад орсон байна. Ингэснээр импортын цементийн тоо хэмжээ буурч, төр, засгаас шат дараатай авч хэрэгжүүлж буй бодлого биелэлээ олсон байдаг.

Зураг 2

Монгол Улсын дотоодын цементийн үйлдвэрлэл
(үйлдвэрээр, мян. тонн)




Эх сурвалж: ҮСХ-ны статистик мэдээлэл, зохиогчийн тооцоогоор

2015 оноос эхлэн дотоодын томоохон цементийн үйлдвэр ашиглалтад орж, зах зээлд цементийн илүүдэл үүсэх, шинэ үйлдвэрүүд бүтээгдэхүүнээ таниулах, үнийн бодлогоор зах зээлд хувь эзлэх шаардлагын үүднээс дөрвөн том үйлдвэр хоорондын өрсөлдөөнийг үүсгэсэн юм. Гэхдээ энэ өрсөлдөөн бодит уу, бодит бус уу? гэдгийг цаг хугацаа харуулах бизээ.

Дээрх дөрвөн том цементийн үйлдвэр (“Мөнхийн баян гал” ХХК БНХАУ-ын хөрөнгө оруулалттай)-ийн нэгээс бусад нь Хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн нөхцөлөөр эх үүсвэр бий болгон барьж байгуулагдсан байдаг. Зээл авах үед эдийн засгийн хувьд үр өгөөж нь эерэг төсөөлөлтэй, харьцангуй богино хугацаанд хөрөнгө оруулалтаа нөхөх зорилготой хэрэгжсэн байдаг.

Бүтээгдэхүүний үнийн болон ханшийн индексийн харьцуулалт



Эх сурвалж: ҮСХ-ны статистик мэдээлэл, зохиогчийн тооцоогоор

Гэхдээ тооцоолол тухайн цаг үеэр байгаагүй нь ойлгомжтой юм. Өндөр өртөг бүхий үйлдвэр, өсөн нэмэгдсэн ханштай уялдсан худалдан авалтын нэмүү өртөг, дээр нь нэгж бүтээгдэхүүний өртөгт сууж буй санхүүгийн зардлын өсөлт голлох байр суурьтай байна.

Ингээд тооцоолоход цаашид цементийн үнэ буурах болов уу? гэсэн асуулт хариугаа хүлээж байна.